



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/323

Мөрөн сум

Захирамжийн холбогдох хэсгийг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.7, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын 2022 оны 70/A2260435 дугаартай албан шаардлагад Мөрөн сумын Засаг даргын Тамгын газарт зориулалтын бусаар Мөрөн сумын 14 дүгээр багийн Сургалт мэдээллийн төвийн ард 25293 м² газрыг эзэмшүүлсэн нь тогтоогдсон тул Мөрөн сумын Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/190 шийдвэрийн 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх газрын бүртгэлийг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН